



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 4/128

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулах, хянах чиг үүргийг хариуцах ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгах, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх шалгуур үзүүлэлт болгох, эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга (Б.Баасандорж), Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (С.Бямбацогт), Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (А.Үйлстөгөлдөр), Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн Тамгын газрын дарга (Д.Баянбилэг), Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга (С.Заяадэлгэр), Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга (Б.Эрдэнэтулга), Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Мягмар), Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг) нарт зөвлөсүгэй.

Б.ЭНХБАЯР

151601499

ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох, хэрэглэгчийг шуурхай, үнэн зөв мэдээллээр хангах, мэдээллийн санг эрхлэн хөтлөх, мэдээлэл оруулагч байгууллагын мэдээлэл солилцох болон үйл ажиллагааны уялдаа холбоог хангахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх) нь олон нийтэд нээлттэй, үнэ төлбөргүй байна.

1.3.Мэдээллийн нэгдсэн сангийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн сан нь Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмч байна.

1.4.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор хууль тогтоомжийн нэгдсэн мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх, хууль тогтоомжийг системчлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

1.5.“Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем” (цаашид “ЭЗМНС” гэх) нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг хэсэг бөгөөд техник болон программ хангамж, мэдээллийн сан, санхүү, хүний нөөц зохион байгуулалтын нэгдсэн тогтолцооноос бүрдэнэ:

Хоёр. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, түүний бүтэц

2.1.Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт, эрх зүйн актын төсөл, түүний дагалдах бичиг баримт (хувийн хэрэг), төрийн мэдээлэл эмхэтгэл болон захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл, хууль зүйн ач холбогдол бүхий бусад мэдээ, мэдээллийн нэгдсэн санг эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан гэнэ:

2.2.Мэдээллийн нэгдсэн сан нь дараах хэсгээс бүрдэнэ:

- 2.1.1.мэдээллийн сан;
- 2.1.2.программ хангамж;
- 2.1.3.техник хангамж.

2.3.Мэдээллийн сан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

- 2.3.1. Монгол Улсын Үндсэн хууль;
- 2.3.2. Монгол Улсын хууль;
- 2.3.3. Монгол Улсын Олон улсын гэрээ;
- 2.3.4. Олон талт Олон улсын гэрээ;
- 2.3.5. Монгол Улсын Их Хурлын тогтоол;
- 2.3.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг;
- 2.3.7. Монгол Улсын Засгийн газрын тогтоол;
- 2.3.8. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр;

2.3.9. Монгол Улсын дээд шүүхийн тогтоол;
2.3.10. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол, шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын тушаал;

2.3.11. Монгол Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр;

2.3.12. Монгол Улсын сайдын тушаал;
2.3.13. Засгийн газрын агентлагийн даргын тушаал;
2.3.14. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол;
2.3.15. Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж;
2.3.16. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол;
2.3.17. Сум, дүүргийн Засаг даргын захирамж;
2.3.18. Зөвлөл, хороо, бусад байгууллагаас баталсан захиргааны хэм хэмжээний акт;

2.3.19. Хууль хяналтын байгууллагын даргын тушаал, хамтарсан тушаал;

2.3.20. Төрийн зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж буй байгууллагын шийдвэр;

2.3.21. Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, заавар, стандартын төсөл;

2.3.22. Хууль тогтоомжийн англи орчуулга;
2.3.23. Хууль зүйн нэр томъёоны тайлбар;
2.3.24. Төрийн мэдээлэл эмхэтгэл, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл болон хууль зүйн ач холбогдол бүхий бусад мэдээ, мэдээлэл.

2.4. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан (www.legalinfo.mn)-д эрх зүйн чиглэлийн сурталчилгааг байрлуулах, олон нийтийн дунд санал асуулга авах үйл ажиллагааг зохион байгуулж болно.

2.5. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн хайлтын хэсэг нь мэдээллийг эрх зүйн актын ангиллаар, статистик буюу огноо, дугаар, гарчиг, хүчин төгөлдөр үйлчилж байгаа эсэх, актын дугаар, бүртгэлийн дугаар, шинээр нэмэгдсэн, үйлчлэл нь зогссон, агуулгын ангилагчаар болон динамик буюу үгээр хайлт хийх боломжтой байна.

Гурав.Мэдээллийн санг эрхлэн хөтлөх, мэдээлэл оруулах

3.1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөгч нь Хууль зүйн үндэсний хүрээлэн байна.

3.2. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн чиг үүрэг:

3.2.1. мэдээлэл оруулагч байгууллагуудын оруулсан хууль тогтоомж, эрх зүйн актын тоо мэдээ болон төсөл оруулагч байгууллагын байршуулсан төсөл, хэлэлцүүлгийн тоо мэдээлэлд үндэслэн мэдээллийн санд мэдээлэл оруулах, хөтлөх нэгдсэн тайлан гаргах;

3.2.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан

хүрээнд сонирхсон этгээдийг мэдээллээр хангах;

3.2.3.Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллагаас боловсруулсан хууль тогтоомж, эрх зүйн акт, заавар, стандартын төслийг мэдээллийн санд оруулах төсөл оруулагч байгууллага болон мэдээлэл оруулагч мэргэжилтэнд санд хандах эрх нээх, хаах болон мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээлэл арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгөх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг ашиглах зааврыг олон нийтэд түгээх, сурталчлах;

3.2.4.мэдээллийн санд байршсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг ангилсан, өөрчлөлт хөдөлгөөн хийгдсэн байдалд ерөнхий хяналт тавьж, алдаатай мэдээллийг мэдээлэл оруулагч байгууллагад мэдээлж, алдааг засуулах арга хэмжээ авах;

3.2.5.мэдээллийн сангийн аюулгүй байдал, тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, сангийн шинэчлэлийг хариуцах;

3.2.6.Мэдээллийн санг хөтлөх, мэдээллийн сангаас мэдээлэл авах, байршуулахад баримтлах аргачлал, зааврыг боловсруулж батлах.

3.2.7.Эрх зүйн актыг үндэслэн гарсан эрх зүйн актын зүйл заалттай холбох, хуулийг үндэслэн гарсан хуультай холбох, эрх зүйн актын нэршлийг холбогдох эмхэтгэлийн дугаартай холбох үйлдлийн зам буюу “Уялдаат холболт” хийх.

3.3. Энэ журмын 2.3.1-2.3.24-т хууль тогтоомж, эрх зүйн акт, эсхүл тэдгээрийн төслийг мэдээллийн санд оруулагчийг Мэдээлэл оруулагч байгууллага гэх бөгөөд үүнд дараах байгууллага хамаарна:

3.3.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар;

3.3.2.Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газар;

3.3.3.Монгол Улсын Дээд Шүүхийн Тамгын газар;

3.3.4.Улсын Их хурлын Тамгын газар;

3.3.5.Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;

3.3.6.Гадаад харилцааны яам;

3.3.7.Хууль зүй, дотоод хэргийн яам;

3.3.8.Хууль зүйн үндэсний хүрээлэн;

3.3.9.Шүүхийн ерөнхий зөвлөл;

3.3.10.Төсөл оруулагч байгууллагууд.

3.4.Энэ журмын 3.3-т заасан байгууллага нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулахдаа энэ журмын хавсралтад заасан мэдээллийн төрөл, хугацааг баримтлах бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

3.4.1.мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулахдаа цахим мэдээллийн бичвэрт “Баримт бичгийн бүрдлүүд, тэдгээрт тавих шаардлага” MNS 510-2:2021, “Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага” MNS 5140-3:2021 Монгол Улсын стандартыг хангасан байх;

3.4.2.энэ журмын 2.3.10-2.3.20-д заасан шийдвэр нь захиргааны хэм хэмжээ тогтоосон нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэр байх;

3.4.3.энэ журмын 2.3-т заасан захиргааны хэм хэмжээний актыг баталсан эрх бүхий этгээд нь уг актын баталгаажсан хуулбарыг цахим хувилбарын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжид ирүүлж захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байх;

3.4.4.хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.3.10-2.3.20-д заасан захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт заасан хугацаанд эх хувиас баталгаажуулсан хуулбар хувь болон цахим хувилбарын хамт Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлсэн байх;

3.4.5.Энэ журмын 3.3-т заасан мэдээлэл оруулагч байгууллага нь энэ журмын 2.5-д заасны дагуу санг ашиглах боломжтой байдлаар мэдээллийн санг бүрэн бүрдүүлэх бөгөөд мэдээллийн санд хөдөлгөөн, өөрчлөлтийг тухай бүрд нь хийж, уялдаат холболтыг холбож, эрх зүйн актын ангиллын дагуу ангилсан байх.

3.5.Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулагч байгууллага нь дараах шаардлагыг хангаж, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусгасан байна.

3.5.1.Хууль зүйн үндэсний хүрээлэн нь мэдээллийн санд мэдээлэл оруулагч нар болон хянагч, мэдээлэл, технологийн ахлах мэргэжилтэнд санд хандах тусгай эрх олгохтой холбоотой асуудлыг хариуцаж, мэдээллийн нэгдсэн сангийн программ хангамжийн хөгжүүлэлт болон хэвийн үйл ажиллагааг хариуцах “эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулагч программист” /цаашид “зохицуулагч программист” гэх/ албан хаагчтай байна;

3.5.2.Мэдээлэл оруулагч байгууллага нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс олгосон тусгай эрхийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулагчийн оруулсан мэдээллийг хянах, илэрсэн алдааны талаар мэдээлэх, алдааг засаж залруулахыг шаардах эрх бүхий “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн хянагч” /цаашид “хянагч” гэх/ албан хаагчтай байна;

3.5.3.Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс олгосон эрхийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулагч программист, хянагч, мэдээлэл оруулах ажлыг хариуцах албан хаагч нь мэдээлэл технологийн мэргэжилтэнтэй байна;

3.5.4.Мэдээлэл оруулагч байгууллага нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс олгосон тусгай эрхийн дагуу мэдээллийн санд энэ журмын 2.3-т заасан хууль тогтоомж, эрх зүйн акт, төсөл, мэдээ, мэдээллийг санд оруулж, эрх зүйн актын өөрчлөлт хөдөлгөөн, ангилал, уялдаат холболт хийх үүрэг бүхий “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл оруулагч” /цаашид “мэдээлэл оруулагч” гэх/ албан хаагчтай байна;

3.5.5.Мэдээлэл оруулагч байгууллага нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс олгосон тусгай эрхийн дагуу мэдээллийн санд энэ журмын 2.3.21-д заасан хууль тогтоомж, эрх зүйн акт, заавар, стандартын төсөл, түүний бүрдүүлбэр, хэлэлцүүлгийн бичлэг оруулах эрх зүйч мэргэжилтэй, хуулийн төсөлд санал авах чиг үүргийг хэрэгжүүлэх “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд төсөл оруулагч” /цаашид төсөл оруулагч гэх/ албан хаагчтай байна;

3.5.6.Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс олгосон эрхийн дагуу эрх зүйн

мэдээллийн нэгдсэн сангийн тоног төхөөрөмж, сүлжээ, сервер болон техник хангамжийн хэвийн, аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааг хариуцах албан хаагч нь мэдээлэл технологийн ахлах мэргэжилтэнтэй байна.

3.6.Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулагч нарыг чадавхжуулах сургалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэн хагас жил тутам зохион байгуулна.

3.7.Мэдээлэл оруулагч байгууллага нь Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулсан мэдээллийн тайланг Хууль зүйн үндэсний хүрээлэнд улирал бүр ирүүлж байна.

Дөрөв. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлт, техник хангамж, аюулгүй ажиллагаа

4.1.Мэдээллийн нэгдсэн сангийн сервер, мэдээллийн сан нь “Үндэсний дата төв” УТҮГ-т байршиж, программ хангамжийг Хууль зүйн үндэсний хүрээлэн хариуцна.

4.2.Мэдээллийн нэгдсэн сангийн хэвийн ажиллагаа, сангийн хөгжүүлэлт, техник хангамжийг сайжруулах, боловсронгуй болгох ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэн хариуцах бөгөөд энэ ажлыг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, туслалцаа авах байдлаар хэрэгжүүлж болно.

4.3.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн зохицуулагч программист нь хянагч, мэдээлэл оруулагч, мэдээлэл технологийн асуудал хариуцсан албан хаагч санд хандах тусгай эрхийг олгохдоо мэдээлэл оруулагч байгууллагын төсвийн шууд захирагчийн ирүүлсэн албан бичигт үндэслэн нэвтрэх нэр, нууц үгийг олгоно. Уг албан бичигт эрх бүхий мэргэжилтний овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаар, цахим шуудангийн хаягийг тусгасан байна.

4.4.Энэ журмын 4.3-т заасан ажилтан бүр санд зөвхөн өөрийн нэвтрэх нэртэй байна.

4.5.Энэ журмын 2.1-д заасан санд нэвтрэх нэр нь тодорхой тооны үсэг, тоогоор илэрхийлэгдсэн байх бөгөөд ажилтны нэр, албан тушаалыг төлөөлсөн байна.

4.6.Амжилтгүй нэвтрэх оролдлогын үед нэвтрэх оролдлогын давталтын хоорондын зай 3 секундээс дээш болон давталтын тоо 3-аас илүүгүй байна. Олон дахин амжилтгүй нэвтэрсэн үед нэвтрэх нэр хаагддаг байхаар тохируулсан байна.

4.7.Энэ журмын 2.1-д заасан санд нэвтрэх амжилтгүй оролдлого бүрд зохицуулагч программистад мэдэгдэж байхаар тохируулсан байна.

4.8.Мэдээллийн нэгдсэн санд амжилтгүй нэвтрэх оролдлогын үед нэвтрэх нэр, нууц үгийн аль нь алдаатай болох нь харагдахгүй байхаар тохируулсан байна.

4.9.Нэвтрэх нэр, нууц үгээр энэ журмын 2.1-д заасан санд давтан холболтыг хийхгүй.

4.10.Мэдээллийн нэгдсэн санд эрх бүхий ажилтны хандах нууц үг алдагдсан, хандалтын механизм саатсан, ажиллагаагүй болсон халдлагад өртсөн шинж илэрсэн тохиолдолд нэн даруй мэдээлэл оруулагч байгууллагаас зохицуулагч

программистад мэдэгдэж санд нэвтрэх эрхийг хаах, идэвхгүй болгох арга хэмжээг авхуулна

4.11.Мэдээлэл оруулагч байгууллагын мэдээллийн нэгдсэн санд хандах эрх бүхий ажилтан ажлаас чөлөөлөгдсөн, өөр албан тушаалд шилжсэн, эсхүл хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан даруйд журмын 4.3-т заасан эрх бүхий албан тушаалтан албан бичгээр Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлж, санд нэвтрэх эрхийг хааж хүчингүй болгоно.

4.12.Дэлгэцийг цоожлох энэ журмын 2.1-д заасан санг 3 минутаас бага хугацаанд идэвхэждэг байхаар тохируулна.

4.13.Энэ журмын 4.3-т заасан ажилтан нь интернэт орчинд ажиллахдаа аливаа вирусийн халдлагад өртөхөөс сэргийлж, цахим шууданг шалгахдаа илгээгчийг болон ирсэн бүх төрлийн өргөтгөлтэй хавсралт файлыг заавал нягтална.

Тав.Хууль тогтоомжийн англи хэлээрх орчуулгыг оруулах, эрхлэн хөтлөх

5.1.Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой олон улсын гэрээ, тайлан болон түүний орчуулгыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн нэгдсэн санд байршуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

5.2.Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төслийг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө хуулийн төсөл болон төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэл дээр орчуулсан хувийн хамт олон нийтэд танилцуулж, санал авахаар мэдээлэл оруулагч нь өөрөө эсхүл Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлж, мэдээллийн нэгдсэн санд байршуулна.

5.3.Худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөлд олон нийт саналаа монгол, эсхүл англи хэлээр өгч болно.

5.4.Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн англи хэлээрх орчуулгыг тухайн хууль тогтоомж батлагдсанаас хойш 90 хоногийн дотор Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулна.

5.5.Энэхүү журмын 5 дахь хэсэгт заасан хууль тогтоомжийн төслийг олон нийтэд хүргэх, англи хэлээр орчуулах ажлын төсвийг тухайн байгууллага төсөвтөө тусгах замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Хууль тогтоомж, эрх зүйн акт, заавар, стандартын төсөлд санал авах, тусгах, хариу өгөх

6.1.Энэ журмын 5.2-т зааснаас бусад төсөл оруулагч байгууллага нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан бүрдүүлбэрийг хангасан төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд танилцуулж санал авахаар өөрөө эсхүл Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлж нэгдсэн санд байршуулна.

6.2.Төсөл оруулагч байгууллага нь төсөлд санал авах хуулийн хугацаа

дууссаны дараа мэдээллийн нэгдсэн санд оруулсан хууль тогтоомж, эрх зүйн акт, заавар, стандартын төсөлд ирүүлсэн санал тус бүрийг судлан үзэж, тусгах эсэх шийдвэрийг гаргаж, хариу тайлбарын хамт Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлнэ.

6.3.Хууль зүйн үндэсний хүрээлэн нь хууль тогтоомж, эрх зүйн акт, заавар, стандартын төсөлд ирүүлсэн саналыг тусгах эсэх шийдвэр, түүний хариу тайлбарыг мэдээллийн нэгдсэн санд оруулна.

Долоо.Санхүүжилт

7.1.Мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлт, программ хангамжийн сайжруулалт, сервер, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт, засвар үйлчилгээнд шаардагдах төсөв хөрөнгийг Хууль зүйн үндэсний хүрээлэн жил бүр төсөвтөө тусгуулах ажлыг хариуцна.

7.2.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Мэдээллийн нэгдсэн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах санхүүгийн дэмжлэгийг үзүүлж, шаардлагатай хөгжүүлэлт хийх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэгч байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

7.3.Мэдээлэл оруулагч байгууллага нь мэдээлэл оруулах мэргэжилтний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, орон тоо нэмэгдүүлэх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах асуудлыг хариуцна.

Найм.Хориглох зүйл

8.1.Мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрх бүхий Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газар, Монгол Улсын Дээд Шүүхийн Тамгын газар, Улсын Их хурлын Тамгын газар, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүүхийн ерөнхий зөвлөл, төсөл оруулагч байгууллагууд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.1.нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулах;

8.1.2.нууц үг шалгагч системийг ажиллуулах;

8.1.3.алсын удирдлагын системүүд ажиллуулах;

8.1.4.сүлжээний протокол задлагч программыг ажиллуулах;

8.1.5.санд бусдын эрхийг ашиглан нэвтрэх;

8.1.6.оюуны өмчийн зөвшөөрөлгүй программ буюу программын хуулбарыг ашиглах.

Ес.Журмын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага

9.1.Энэхүү журмын хэрэгжилтэд мэдээлэл оруулагч байгууллагын удирдлага хяналт тавьж ажиллана.

9.2.Мэдээлэл оруулагч болон төсөл оруулагч байгууллага мэдээллийн нэгдсэн санд оруулсан мэдээллийн техникийн болон агуулгын үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцна.

9.3.Мэдээллийн нэгдсэн санд оруулсан хууль тогтоомж, эрх зүйн актын хувьд маргаан, эргэлзээ гарвал тухайн хууль тогтоомж, эрх зүйн актын цаасан эх хувийг

баримтална.

9.4.Энэ журмын 2.1-д заасан санд мэдээллийг хугацаа хожимдуулж оруулсан эсхүл оруулах ёстой мэдээллийг алдаатай оруулсан эсхүл оруулаагүй үйлдэл нь илтэд санаатай, гэмт хэргийн шинжийг агуулаагүй бол тухайн байгууллагын удирдлага буруутай ажилтанд байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэж, алдааг нэн даруй засварлах арга хэмжээ авна.

9.5.Хууль зүйн үндэсний хүрээлэн нь энэ журамд дурдсан байгууллагын оруулсан хууль тогтоомж болон эрх зүйн бусад актыг бүрэн оруулсан эсэхэд хяналт тавих ерөнхий хянагчийн эрхтэй байх бөгөөд энэ журмын 3.1-д заасны дагуу ажиллана.

--- оОо ---

ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНД БАЙРШУУЛАХ МЭДЭЭЛЛИЙН
ТӨРӨЛ, ХУГАЦАА, ОРУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА

Д/д	Байгууллагын нэр	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулах мэдээлэл	Оруулах хугацаа
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, тэдгээрийн үндэсний бичгийн хувилбар; - өөрчлөлт хөдөлгөөн; - уялдаат холболт;	Хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 өдрийн дотор
2	Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газар	- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, тэдгээрийн үндэсний бичгийн хувилбар; - өөрчлөлт хөдөлгөөн; - уялдаат холболт;	Дүгнэлт, тогтоолыг ёсчилсноос хойш ажлын 5 өдрийн дотор
3	Монгол Улсын Дээд Шүүхийн Тамгын газар	- Улсын Дээд Шүүхийн хууль тайлбарласан тогтоол, тэдгээрийн үндэсний бичгийн хувилбар; - өөрчлөлт хөдөлгөөн; - уялдаат холболт;	Ёсчлогдсоноос хойш ажлын 10 өдрийн дотор
4	УИХ-ын Тамгын газар	- Монгол Улсын Үндсэн хууль; - Монгол Улсын хууль; - УИХ-ын тогтоол; - тэдгээрийн үндэсний бичгийн хувилбар; - УИХ-ын соёрхон баталсан олон улсын гэрээ; - Төрийн мэдээлэл эмхэтгэл; - өөрчлөлт хөдөлгөөн; - Дээрх хууль тогтоомжийн төсөл; - уялдаат холболт;	“Төрийн мэдээлэл эмхэтгэл”-д нийтлэгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор
5	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	- Засгийн газрын тогтоол; - тэдгээрийн үндэсний бичгийн хувилбар; - өөрчлөлт хөдөлгөөн; - уялдаат холболт;	Хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 өдрийн дотор
6	Гадаад харилцааны яам	- Монгол Улсын олон улсын гэрээ; - Олон талт олон улсын гэрээ; - Англи хэл дээрх орчуулга; - өөрчлөлт хөдөлгөөн; - уялдаат холболт;	“Төрийн мэдээлэл эмхэтгэл”-д нийтлэгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор

7	Хууль зүй, дотоод хэргийн яам	- Монгол Улсын сайдын тушаал; - өөрчлөлт хөдөлгөөн; - Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, заавар, стандартын төсөл, тэдгээрийн бүрдүүлбэр; - уялдаат холболт;	Тухай бүр
8	Хууль зүйн үндэсний хүрээлэн	- Засгийн газрын агентлагын даргын тушаал; - УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр; - Аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоол; - Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж; - Сум, дүүргийн ИТХ-ын тогтоол; - Сум, дүүргийн Засаг даргын захирамж; - Төрийн зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж буй байгууллагын шийдвэр; - Хууль, хяналтын байгууллагын шийдвэр; - Зөвлөл, хороо бусад байгууллагын шийдвэр; - өөрчлөлт хөдөлгөөн; - Захиргааны хэм хэмжээний акт, заавар, стандартын төсөл, тэдгээрийн бүрдүүлбэр; - уялдаат холболт; - Хууль тогтоомжийн англи орчуулга; - Хууль зүйн нэр томъёоны тайлбар; - Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл; - Хууль зүйн ач холбогдол бүхий мэдээ, мэдээлэл;	Тухай бүр
9	Шүүхийн ерөнхий зөвлөл	- Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол; - Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын тушаал;	Тухай бүр
10	Төсөл оруулагч байгууллага	- Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, заавар, стандартын төсөл, хэлэлцүүлгийн бичлэг;	Тухай бүр

--- oOo ---